



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/282

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.3.4, 9.3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мөрөн сумын нутаг дэвсгэрт ил задгай хог хаягдал хараа хяналтгүй хаяж, хувиараа бой хийдэг иргэд малын гаралтай хог хаягдал хаях нь ихсэж, үерийн далан, гуу, жалгын ойр хавьд хог хаягдал хаяж байгаад хяналт тавих, иргэдийн хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажил зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийг хуралдуулж төлөвлөгөөг 2024 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн дотор боловсруулж, нэг сарын хугацаанд хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар
сарын 04-ний өдрийн /28/ тоот захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

- Х.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)
- С.Ганболд (аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
- П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
- Л.Ариунаа (Мал эмнэлгийн газрын дарга)
- Ө.Баттулга (аймгийн авто тээврийн төвийн дарга)
- М.Үүрийнбаяр (Эрүүл мэндийн газрын дарга)
- Б.Ганзориг (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)
- Б.Энхгэрэл (Дэлгэрмөрөншигэд голын сав газрын ахлах мэргэжилтэн)
- Б.Ганболд (Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан байцаагч, Цагдаагын ахлах дэслэгч)
- Ц.Зоригт (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ний гүйцэтгэх захирал)
- Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлстийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ч.Батсүх (Мөрөн сумын Засаг даргын орлогч)